

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№18/479

ШУС, НУС

2017

**МОНГОЛЫН ТЕЛЕВИЗҮҮДИЙН ТОК ШОУ БУЮУХЭЛБЭРЭЭ ОЛООГҮЙ
ХЭЛБЭРДЭЛТ**

Т.Өнөрсайхан*, Д.Оюунсүрэн**

*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн багш, докторант

**МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн, нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үг: ток шоу, холимог хөтөлбөр, инфотейнмент, үндсэн гурвалжин, телевиз, үзэгч

“Зугаацуулах харилцаа” гэсэн “малгай” дор өнөө цагийн телевизийн бүтээлүүдийн өнгө төрхийг тодорхойлж буй холимог хөтөлбөрүүд багтана. Эдүгэйн инфотейнмент, инфомершиал, политейнментхэдийнэ шинэ ойлголт байхаа больж, өдөр тутмын хэрэглэгдэхүүн болжээ. Сэтгүүл зүй судлаач В.Л. Цвик “Хэлбэрзах зээлийн эрэлтээс үүсдэг бол төрөл зүйлгоо зүйн илэрхийлэл”¹ гэж телевизийн бүтээлийн онцлогийг тодорхойлсон байдаг. Өөрөөр хэлбэл, бүтээлийн үндсэн зорилго ямарч цаг үед хэвээр хадгалагдана. Харин нийгмийн өөрчлөлт, шаардлагаар зорилгоо биелүүлэх арга хэрэгсэл нь тогтворгүй, хүлээн авагчийн эрэлт хэрэгцээнээс шалтгаалж, хувьсан өөрчлөгдөж байдаг.

Телевизийн холимог хөтөлбөрүүд 1960-аад оны үеэс ажиглагдах болжээ. Улсын болон олон нийтийн телевизийн нэг хэлбэрийн, хэт баригдмал “уйтгар-тай” өгөгдөл, арилжааны телевизүүдийн мөнгө санхүү, дуулиан шуугиан хөөж, нийгмийн сөрөг талыг харуулах нь давамгайлсан хэлбэр төдий нэвтрүүлгүүд үзэгчдийн шүүмжлэлийг дагуулах болсон байна. Тиймээс сонирхолтой өгөгдөлтэй боловч сэтгүүл зүйн үндсэн үүргүүдийг биелүүлсэн нэвтрүүлгүүдийнэхний туршилтууд хийгджээ.

Холимог хөтөлбөрүүд нэрнээсээ эхлээд энтертейнмент буюу зугаацуулах, хөгжөөх гэсэн утга санааг шууд агуулна. Тус тусын үндсэн төрөл зүйлийн онцлогийг хадгалах боловч “зугаацуулах харилцаа”-ны ерөнхий зарчмыг баримталдаг. Тэдний ижил төстэй байдлыг илэрхийлж буй “тейнмент” гэсэн төгсгөл,

- Сонин хачин, онцгой гойд, хөгжилтэй зугаатай гэсэн ойлголтыг өдөөх
- Амьдралын өдөр тутмын зан үйлийг ер бусын байдлаар харуулах,
- Нийгмийн хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээ, ёс зүйг зөрчиж байгаа ч хүмүүсийн хэдийнэ дасал болж, дөжирсөн аливаа зүйлд “дүр” бий болгох,
- Нийгмийн янз бүрийн бүлгийн гишүүдийг ижил төстэй талуудаар нь нэгтгэх,
- Тухайн цаг үеийг илэрхийлэгч “дүр төрх”-өөр дамжуулж нийгмийн үнэлэмжийг тодорхойлох,
- Сонирхолтой шийдэлд татагдсан олон нийтийн санаа бодолд, нийгмийн үнэт зүйлээр дамжуулж нөлөөлөх гэсэн утга санаа, зорилго агуулдаг.

Энэхүү зорилгыг үр дүнд хүргэж, нөлөөллийг нь нэмэгдүүлэхийн тулд дүрслэлийн болон аман харилцааны олон талт аргыг ашиглана. Хамгийн ойр жишээ нь инфотейнмент хөтөлбөрийн бүх талыг өөртөө шингээсэн ток шоу /talk show.анг/ юм.

Сэтгүүлч, оролцогчоос бүтсэн, зорилго бүхий яриаг ярилцлага гэнэ. Энэ талаас нь авч үзвэл ток шоу телевизийн ярилцлагын төрлийн нэвтрүүлэг мөн. Ток шоуны ярилцлагын хэв шинж нь нэг урсгалт яриа биш харин нэг цэгээс хэд хэдэн зүг тарсан, эргээд олон талаас нэг цэгт төвлөрдөг онцлогтой. Хэлбэрийн хувьд олон нийтийг хамарч, тэдний оролцоогоор бүтдэг, санаа бодлыг нь тусгасан хэлэлцүүлэг байдгаараа ялгаатай. Тиймээс сэтгүүлч-оролцогч хоёрын харилцан яриа ток шоу биш юм. Нөгөө талаар, ток шоу гэрэл

зүйлийн хувьд асуудлыг олон талаас нь авч үздэг хэлэлцүүлгийн хэв шинжтэй гэж болох ч сэдвийн ер бусын, маргаант байдал, хязгаарлагдмал бус хүрээгээрээ ялгарна. Анхны асуултыг тавихаас эхлээд, дараа нь юу үзүүлэх бол гэсэн хүлээлт, үйл явдлын хурд, таахын аргагүй огцом эргэлт, үзэгч, оролцогчийн санаа бодолд нөлөөлж буй хөтөлгөчийн харилцаа, үг яриа, уран чадвар “шоу” гэсэн онцлогийг нь тодотгодог. Ток шоу гэдвийн хувьд дараах байдлаар ангилж болно.

-Олон нийтийн сонирхол татсан сэдэв бүхий ток шоу. Улс төр, эдийн засаг, нийгмийн амьдрал, шоу бизнес гэх зэрэг олон нийтийн анхаарал татаж, ярианы гол сэдэв болсон асуудлыг өгүүлдэг. Ийм сэдэвт ток шоунд нийгэмд байдаг тулгамдсан асуудлыг тухайн цаг үед болсон аль нэг үйл явдлаар “дүржүүлж” үзүүлдэггүй. Сэдэв тохиолдлын, гэнэтийн, нэг удаагийнх байдаг. Жишээ нь: Сумогийн их аварга шахалтанд орж зодог тайлсан уу, УИХ-ын гишүүн зэвсгийн наймаа хийсэн үү, Шүүх эмнэлгийн эргэлзээтэй дүгнэлт: 13 настай охин архи хэтрүүлэн хэрэглэсэн үү, УИХ-ын гишүүнхүчирхийлэгч үү, Сири улсын талаар АНУ, ОХУ-ын байр суурь гэх мэт.

-Дотоод сэтгэлийн асуудлыг хөндсөн сэдэвтэй ток шоу. Хүмүүсийнхувийн амьдрал, эмэгтэйчүүдийн гэж нэрлэгддэг сэдвийг сонгон авдгаараа онцлогтой. Гэр бүл, гоо сайхан, ажил мэргэжил, хайр дурлал гэх мэт. Олон нийтийн сонирхлыг татсан сэдэв бүхий ток шоунаас ялгарах онцлог нь нийгмийн хэм хэмжээг зөрчиж, гажсан боловч амьдралд байнга тохиолдож байдаг

асуудлыг тухайн цаг үед гарч ирсэн ижил төстэй үйл явдлаар “дүржүүлж”, төлөөлүүлж үзүүлдэг. Жишээ нь, “Нөхөртөө хаягдсан шалт-гаан” гэсэн сэдвээр нэг дугаар хийж болно. Энэ тохиолдолд үзэгчдийн анхаарлыг татах олны танил хүний хувийн амьдралыг жишээ болгох, эсвэл зөрчил маргаан ихтэй, хохирогч олон-тойхаягдсан тохиолдлыг “дүр” болгон сонгон авах юм.

- Тусгайлсан сэдэвт ток шоу. Анх сонгож авсан сэдвээсээ гажилгүй нэг төрлийн асуудлыг олон талаас нь ярилцана. Хоолны, эрүүл мэндийн, хүүхдийн гэсэн сэдвүүд түгээмэл байдаг. Ийм ток шоу бүх төрлийн зөвлөгөөний булан гэж нэрлэж болно. Зорилтот үзэгчдийн хүрээ харьцангуй хязгаарлагдмал юм.

Зарим тохиолдолд үзэгчдийн хамрах хүрээгээ нэмэгдүүлэх зорилгоор дээрх гурван төрлийг нэгтгэн холимог сэдэвт ток шоу хийх нь бий. Гэхдээ энэ тохиолдолд зорилтот бүлгээ шууд тодорхойлоогүй учраас болзолт хүлээн авагчдаас илүү тохиолдлын шинжтэй үзэлт давамгайлдаг.

Сэдвийн сонголтоорооонцлогоо харуулдаг ток шоу гхэлбэрийн хувьд “үндсэн гурвалжин” болох “хөтлөгч – оролцогч -студийн үзэгч” гэсэн бүтэц тодорхойлно. Гурвуулаа гол үүрэгтэй, хэн нэгэнд нь давуу буюу дутмаг тал байхгүй, ижил тэгш оролцоотой юм. Хэлэлцэж буй асуудлыг олон талаас нь авч үзэх, сэтгүүл зүйн бүтээлийн хувьд эх сурвалжийн бүх түвшинг хангах, нэвтрүүлгийг өргөн хүрээ хамарсан, сонирхолтой болгох зорилгоор гурван талт оролцогч бүрт дагавар бүлэг үүсгэдэг. Үүнд:

- Студийн үзэгчид – дэлгэцээр хүлээн авч үзэж буй үзэгчид,

- Оролцогчид. Агуулгын хувьд: хэд хэдэн оролцогч – эерэг болон сөрөг байр суурийг илэрхийлнэ, хэлбэрийн хувьд: студийн оролцогч- телевизийн төрөл бүрийн технологийн давуу талыг ашиглан орон зай, цаг хугацааны ялгаатай нөхцөлд байгаа оролцогчид,
- Хөтлөгч – хөндлөнгийн шинжээчид. Хөтлөгч ерөнхий чиглүүлэгч, уур амьсгалыг бүрдүүлэгч “дүр” бол хөндлөнгийн шинжээч асуудалд мэргэжлийн байр суурьнаас, шинжлэх ухааны үндэслэлтэй хандах, хөтлөгч-туслахын үүргийг биелүүлнэ. Ток шоу “үндсэн гурвалжин” болон хөндлөнгийн шинжээчдийн хэсэггүйгээр төсөөлөх боломжгүй.

Үзэгчид. Ток шоуны студийн үзэгчдийг хоёр ангилна. Ямар ч ток шоу сонирхолтой, маргаантай болгох зорилгоор “мэргэжлийн үзэгч” буюу “жүжигчин-үзэгч” оролцдог. Студийн үзэгчдийн дунд сууж шаардлагатай үед асуудлыг дэвэргэж, өдөөж, үйл явдлын хандлагыг аль нэг тийш өөрчлөх зорилго бүхий асуулт тавих, үйлдэл хийх, бусад үзэгчдийн санаа бодолд нөлөөлж тодорхой уур амьсгалыг бүрдүүлэх үүрэгтэй. Зарим тохиолдолд нэр алдартай хүмүүс ч үзэгчийн суудалд суух нь бий.

Телевизийн нэвтрүүлгийн багийнхан студийн үзэгчдийг цуглуулах ажлыг хийдэггүй. Америк болон Европын орнуудад ийм төрлийн “мэргэжлийн үзэгч”-дийг бүртгэж, цуглуулдаг тусгай агентлагууд үйл ажиллагаа явуулдаг. Жишээлбэл, “ОХУ-ын “Вьюр” агентлаг “Первый канал”, “ТНТ”, “СТС”, “MTV Russia”, “Муз ТВ” телевиз,

“Мосфильм”, “Ленфильм” зэрэг кино студитэй хамтарч ажиллан, жүжигчин олох ажил хийдэг”² байна. Ихэнхдээ олны танил болоогүй жүжигчдийг “мэргэжлийн үзэгч”-ээр сонгодог. Нэг жүжигчин жилдээ хоёроос гурван удаа л ийм төрлийн үзэгчээр оролцох боломжтой. Үзэгчдийн итгэл үнэмш-лийг хадгалж, үнэн бодитой байлгах үүднээс “мэргэжлийн үзэгч”-ийг байнга сольдог юм.

Студийн үзэгчдийн цөм хэсгийг хүсэл сонирхлоороо оролцдог жирийн иргэд бүрдүүлнэ. Дэлхийн томоохон телевизүүд олон жил гарч буй, үзэгч ихтэй ток шоуны студийн үзэгчийн суудлын тасалбарыг худалддаг. Цахим хаяг болон бусад хэлбэрээр ток шоуны сэдвийг зарлаж, зураг авалт шууд хийх эсвэл урьдчилсан бичлэгийн өдөр, цагийг товлонтасалбараа гаргана. Ийм төрлийн үзэгчид телевизийн эргэх холбоог сайжруулж, нэвтрүүлгийн чансааг мэдэх бас нэг боломж юм. Студийн үзэгчдийн тусламжтайгаар хэлэлцэж буй тухайн асуудлын талаар нийгмийн үнэлэмжийг тодорхойлж болдог онцлогтой.

Ток шоу шууд эфирээр нэвтэрч байгаа тохиолдолд телевиз үзэгч бас нэгэн оролцогч болно. Утас болон зурвас (мессеж)-аар, эсвэл телемост, телемарафон хэлбэрээр өөрийн үзэл бодлоо илэрхийлж, оролцох боломжтой. Ток шоу тогтмол байх нь чухал. Ингэснээр телевиз үзэгч ток шоу эхлэх цагийг хүлээж, дэвшүүлж тавьсан асуудалд өөрийн зүгээс хандахад сэтгэл зүйн хувьд бэлтгэгдсэн байна.

Хөтлөгч. Ток шоу өнөөгийн өнгө төрхөө олоход АНУ-ын сэтгүүлч Фил Донахью гол нөлөө үзүүлжээ. Шууд нэвтрүүлгийн үеэр цаг нь дуусаагүй

байхад асуултгүй болсон байна. Ямар нэгэн аргаар нэвтрүүлгийг үргэлжлүүлэхийн тулд студийн үзэгчид хандан “Танд оролцогчоос асуух зүйл байна уу?” гэжээ. Хөтлөгчийн тусламжтай оролцогч-үзэгчийн хооронд шууд холбоо үүсч, сонирхолтой олон асуулт үзэгчид тавьснаар тус нэвтрүүлэг олны анхаарал татсан байна. Санаандгүй мэт боловч телевизийн бүтээлийн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн энэ асуулт ток шоу хэлбэрийн хувьд бүрэлдэн тогтох эхний алхам болсон гэж тооцогддог.

Шинэ төрлийн нэвтрүүлгийн ерөнхий хэлбэрийн талаарх төсөөллийг бий болгосон Фил Донахью олны анхаарлыг татахын тулд янз бүрээр оролдож байсан байна. Орон нутгийн жижиг телевизийн өглөөний хөтөлбөрт оролцох хүсэлтэй нэр хүндтэй зочин ховор учраас алдартай хэн нэгэн биш анхаарал татсан шуугиант сэдвийг төв асуудлаа болгож, телевизийн шууд эфирт олон талт хэлэлцүүлэг өрнүүлэх болжээ. Ингэх-дээ Фил Донахью, бусдыг татах өөрийн онцлог/харизм/, хошин шогийн мэд-рэмж, хүмүүст үзүүлэх нөлөө, хурц, зоримог асуулт зэрэг хувь хүний болон мэргэжлийн ур чадвараа ашиглаж байв. Түүний бүтээсэн хөтлөгчийн “дүр” өнөөгийн ток шоуны хөтлөгчийн онцлогийг илэрхийлсээр байна.

Ток шоу хэрхэн эхэлж, өрнөж, төгсөх нь хөтлөгчийн ур чадвараас шууд хамаарна. Хөтлөгч үйл явдлын цөм байж, сэдвийн өгөгдөл, агуулга, гаргалгааг чиглүүлж өгөхөд чухал үүрэгтэй. Тиймээс сийрэг сэргэлэн байдал, хошин шогийн мэдрэмж, баялаг үг яриа, олон нийтэд нөлөөлөх чадвар, гаднах дүр төрх, өөрийн гэсэн онцлогийг шаарддаг. Бусад төрлийн нэвтрүүлгээс ток шоу хөтлөгчийн хувь

шинжийн гэдгээрээ онцлогтой. Гэхдээ энэ бол ерөнхий харагдах байдал юм. Хөтлөгчийн оролцоог студийн үзэгч-оролцогчоос дээгүүр тавих учиргүй.

Чиглүүлэгч, нөлөөлөгч, уур амьсгалыг бүрдүүлэгч үндсэн хөтлөгчөөс мэргэжлийн түвшний мэдлэг, шинжлэх ухаанч байдал, нийгмийн хүлээн зөвшөөрөгдсөн, сахин мөрдөх ёстой тогтсон хэм хэмжээнд захирагдаж байдгаараа хөндлөнгийн шинжээч ялгаатай. Мэргэжлийн байгууллагын төлөөлөл, төрийн байгууллагын ажилтан, салбарын судлаач гэх мэттухайн цаг мөчид сэтгэл хөдлөлөөс ангид байж, асуудалд мэргэжлийн үүднээс хандах үүрэг тэдэнд ноогддог. Сэтгүүл зүйн хувьд мэдээллийн тэнцвэрт байдлыг хадгалахчухал нөлөөтэй юм.

Оролцогчид. Ток шоуны сэдэв ер бусын, зөрчилт байдлыг харуулдаг учраас “оролцогч” гэдэг үг ганц тоон дээр хэрэглэгдэхгүй. Хоёр буюу түүнээс дээш тал байж зөрчил үүсдэг. Ток шоу мэтгэлцээн, хэлэлцүүлгийн хэв шинжийг агуулдаг чанараараа тухайн асуудлын эерэг болон эсрэг дүрийг буюу эх сурвалжийн түвшний хувьд сонирхлын болон үр дагавар хүртэгсдийг оролцуулна. Мөн аль аль талаас нэг оролцогч байх нь хөтлөгч, хөндлөнгийн шинжээч, үзэгчдийн зүгээс ирэх “дарамт”, асуултын урсгалыг давж гарахад хүндрэлтэй гэж тооцон дэмжигчдийн хэсгийг урьдаг. Ихэнхдээ тухай асуудал болон оролцогчийг сайн мэдэх ар гэр, найз нөхөд нь байна. Тэд дэмжлэг өгөхөөс гадна оролцогч талуудын өгч буй мэдээллийг батлах, эсэргүүцэх бас нэгэн эх сурвалж болдог.

“Үндсэн гурвалжинг” бүрдүүлэгчдийн бүх талын оролцоог хангаж байж

сая ток шоуны хэлбэрийг олдог. Гэхдээ зөвхөн оролцох бүрэлдэхүүнээр хангаснаар бүрэн утгаараа ток шоу боллоо гэсэн үг биш юм. Сэдэв, ярилцлагыг хийж буй байдал, бүх талын тэгш оролцоо, үзэхүйн сонирхлыг татах янз бүрийн өгөгдлүүд ток шоуны шинжийг илэрхийлнэ.

Монгол Улсын хувьд анх телевиз байгуулагдсанаас хойш 50 жилийн доторбие даасан салбар болтлоо хөгжиж, бүх төрөл хэлбэрийн бүтээлүүдийг хийж байна. Энэ бол сайшаалтай алхам юм. Гэхдээ тооны хажуугаар чанарыг мартаж болохгүй. “Тооноос чанарт шилжих, чанараас үр дүнд хүрэхийн төлөө манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд шинэ менежмент, шинэ сэтгэлгээ, идэвх санаачлага, бичлэгийн цоо шинэ арга барил шаардлагатай”³ гэж доктор, профессор М.Зулькафиль тэмдэглэсэн байна.

Монголын телевизийн практикт ток шоу цоо шинэ зүйл биш. 1990-ээд оноос өмнө ток шоу шинжтэй теле уулзалтууд хийгдэж байсан. Бүрэн утгаараа өнөөдрийн түвшинд хүрсэн холимог хөтөлбөр биш ч гэлээ ерөнхийдөө хэв шинжийг нь агуулж байв. Хөтлөгч, оролцогч, студийн үзэгчдээс бүрдсэн таблойд буюу хялбаршуулсан хувилбар, ток шоуны шинжтэй байсан гэж үзэх үндэслэлтэй юм.

Зохиогч дээр өгүүлсэн онол, арга зүйн тайлбартаа үндэслэн Монголын телевизүүдийн хийж буй ток шоу гэсэн тодотголтой нэвтрүүлгүүд энэ төрлийн онцлог, хэв шинжийг хэрхэн тусгаж, хадгалж байгаа талаар бичил ажиглалт судалгаа хийсэн болно.

Судалгаанд, МҮОНТ-ийн “Нандин”, “TV5” телевизийн “Зэвүүн яриа”, “Монгол Улсаа хөгжүүлье!”, “TV9” телевизийн “Дотно сэдэв”,

“UBS”телевизийн “Сайн уу, Сайнаа”, ETV телевизийн “Хурууны хээ”, “Боловсрол” телевизийн “17 нас”, “Ялалт”, “VTV”телевизийн “Шударга ярья” нэвтрүүл-гийг сонгож авлаа.

Эдгээрээс МҮОНТ-ийн “Нандин”, “TV5”телевизийн “Монгол Улсаа хөгжүүлье!”, “TV9”телевизийн “Дотно сэдэв”, “UBS”телевизийн “Сайн уу, Сайнаа”, “ETV”телевизийн “Хурууны хээ”, “Боловсрол” телевизийн “17 нас”, “Ялалт”, “VTV”телевизийн “Шударга ярья” нэвтрүүлэг “ток шоу” гэсэн тодотголыг нэрнийхээ ард, нэвтрүүл-гийн эхэнд бичсэн байна. “TV5”теле-визийн “Зэвүүн яриа” нэвтрүүлгийн хөтлөгч эхлэл бүртээ “Зэвүүн яриа ток шоуны.....зочин.....” гэж хэлж байгаа учраас энэ төрөлд багтаан судалгаанд хамруулав.

Харьцуулсан судалгаанд нэвтрүүлгүүдийг гурван бүлэг болгон ангиллаа.

Нэгдүгээр бүлэгт, “TV5”телевизийн “Монгол Улсаа хөгжүүлье!”, “Зэвүүн яриа”, “Боловсрол” телевизийн “Ялалт”, “VTV”телевизийн “Шударга ярья”,

Хоёрдугаар бүлэгт, “TV9”телевизийн “Дотно сэдэв”, “Боловсрол” телевизийн “17 нас”, “ETV”телевизийн “Хурууны хээ”,

Гуравдугаар бүлэгт, МҮОНТ-ийн “Нандин”, “UBS”телевизийн “Сайн уу, Сайнаа” нэвтрүүлэг багтана.

Нэгдүгээрт бүлэгт орсон “TV5”телевизийн “Монгол Улсаа хөгжүүлье!”, “Зэвүүн яриа”, “Боловсрол” телевизийн “Ялалт”,

“VTV”телевизийн “Шударга ярья” нэвтрүүлгийг “ток шоу” гэж үзэх боломжгүй юм.

“TV5”телевизийн “Монгол Улсаа хөгжүүлье!”, “VTV”телевизийн “Шударга ярья” нэвтрүүлэг хөтлөгч-оролцогчийн хооронд тухайн цаг үед яригдаж буй идэвхтэй сэдэв бүхий мэдээлсэн ярилцлага байна. “Зэвүүн яриа” нэвтрүүлэг тухайн цаг үеийн идэвхтэй сэдэв биш ч олны анхаарлыг татаж буй хэн нэгнийг урьж оролцуулан, хөтлөгч өөрийн санаа бодлыг илэрхийлж байгаа шинжээрээ хөтлөгч-оролцогчийн хооронд өрнөж буй чөлөөт ярилцлага юм. “Боловсрол” суваг телевизийн “Ялалт” нэвтрүүлгийн тухайд оролцогчийн хувийн амьдрал, амжилт бүтээлийг ярилцаж, хэд хэдэн эх сурвалжийн тусламжтайгаар гол дүрийг тодотгож байгаа нь хөрөг ярилцлагын шинжтэй байна. Тиймээс нэгдүгээр бүлэгт багтсан дээрх дөрвөн нэвтрүүлэг “ток шоу” биш, телевизийн студийн ярилцлага юм.

Хоёрдугаар бүлэгт багтсан “TV9”телевизийн “Дотно сэдэв”, “Боловсрол” телевизийн “17 нас”, “ETV”телевизийн “Хурууны хээ” нэвтрүүлгийг ток шоу гэж тодотгож, эхлэл хэсэгт нь бичжээ. “Дотно сэдэв”, “Хурууны хээ” нэвтрүүл-гийн цөөн хэдэн дугаарыг ток шоуны таблойд буюу хялбарчилсан, өөрөөр хэлбэл, “ток шоу шинж”-тэй нэвтрүүлэг гэж үзэж болно. Хөтлөгч-оролцогч-студийн зочингэсэн ток шоу илтгэх ерөнхий хэлбэр байна. Гэхдээ гурвал-жингийн эн тэнцүү оролцоо байхгүй, хурц сонирхолтой сэдэв, шийдэлгүй, ерөнхийдөө хөтлөгч-оролцогч хоёрын хооронд өрнөж буй чөлөөт ярилцлагын шинжтэй. Студид ирсэн үзэгчид нэг

хоёр асуулт асуухаас хэтрэхгүй, оролцооны хувьд дутмаг байдал ажиглагдаж байна. Цөөн хэдэн дугаарт, тохиолдлын шинжтэйгээр үзэгчдийн оролцоог эс тооцвол “Хурууны хээ” нэвтрүүлэг нь чөлөөт сэдвээр студид хийж буй ярилцлага юм. Ток шоу гэж үзэх үндэслэл алга байна.

“Дотно сэдэв” нэвтрүүлэг ток шоу гэсэн албан ёсны тодотголтой боловч яг үнэндээ ямар нэвтрүүлгийн төрөлд хамаарах нь тодорхойгүй, сэдэв болон хэлбэрийн хувьд цуглуулга шиг гэж хэлж болохоор юм. Цөөн хэдэн дугаар нь студийн үзэгч-хөтлөгч-оролцогч бүхий “үндсэн гурвалжин”-г илэрхийлсэн ток шоуны шинжтэй, мөн гудамжинд оролцогчоо даган ярьж яваа сурвалжлага-ярилцлага бүхий дугаар, студид оролцогч-хөтлөгч бүхий чөлөөт ярилцлага гэх мэт янз бүрийн хэлбэрээр бэлтгэжээ. Бүхлээр нь тус нэвтрүүлгийг хэлбэрийн хувьд тогтмол өгөгдөлтэй, сэдэв идэвхтэй, олон талт асуудлын шийдлийг олохыг зорьдог ток шоуны шинжтэй гэж үзэх боломжгүй юм.

“17 нас” нэвтрүүлэг ток шоуны гурвалжин, хөтлөгч-оролцогч-студийн үзэгч гэсэн хэлбэртэй боловч студийн үзэгчдийн оролцоо бараг байхгүй, хөтлөгч асууж оролцогч хариулах зарчмаар явагддаг, оролцогчийн хувийн амьдрал бага насыг өгүүлсэн хөрөг нэвтрүүлгийн шинжтэй чөлөөт ярилцлага байна.

Гуравдугаар бүлэгт МҮОНТ-ийн “Нандин”, “UBS” телевизийн “Сайн уу, Сайнаа” нэвтрүүлэг багтана. Энэ хоёр нэвтрүүлэгт хөтлөгч –оролцогч-студийн үзэгч гэсэн “үндсэн гурвалжин” тогтмол оролцдог нь давуу тал юм. Ток шоунд зайлшгүй байх

ёстой нэг оролцогч бол тухайн асуудлыг сайн мэдэх албан хаагч, мэргэжилтэн, судлаач гэх мэт сэдэвт мэргэжлийн үүднээс шууд хамааралтай хөндлөнгийн шинжээчид байдаг. Тэд ток шоу сэтгүүл зүйн бүтээлийнх нь хувьд эх сурвалжийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилготой оролцогчид юм. “Сайн уу, Сайнаа!” болон “Нандин” нэвтрүүлэгт хөндлөн-гийн шинжээчид оролцдоггүй, студийн үзэгчдийн оролцоо бага, хөтлөгчөөс оролцогч гэсэн асуултын нэг урсгалтай байгаа нь ажиглагдлаа. Хөндлөнгийн шинжээчдийн хэсгийг орхигдуулснаар олон талаас нь шүүн хэлэлцэж, шийдэлд хүрэхийг зорьдог ток шоуны үндсэн зорилгыг биелүүлж чадахгүй, нэг тал давамгайлсан ярилцлагын хэв шинжтэй болжээ.

Ток шоуны сэдэв нь хүний алдар нэр дээр төвлөрөхөөс илүү хийсэн үйлдэлд илүү анхаардаг онцлогтой. Илэрхийллийн арга нь эрс огцом шийдэлтэй, гэнэтийн үйл явдал, баримтаар баялаг, хөтлөгчийн үндсэн чиглүүлгээс гадна студийн оролцогчид нэмэлт санааг байнга гаргаж тавьдаг. Дээрх хоёр нэвтрүүлгийн оролцогчид, сэдвийн сонголтыг харахад ток шоуны онцлог болох хурц сэдэв, зөрчил байхгүй, “Сайн уу, Сайнаа” нэвтрүүлэг хөрөг ярилцлагын шинжтэй, “Нандин” нэвтрүүлэг чөлөөт ярилцлагын шинжтэй байна.

Ток шоуны оролцогч-хөтлөгч-студийн үзэгч бүхий зөвхөн гаднах хэлбэрийг нь хуулбарласан тохиолдлыг “ток шоу шинж”-тэй /табloid/ нэвтрүүлэг гэж нэрлэдэг. Өөрөөр хэлбэл, ток шоу гэж нэрлэж байгаа боловч асуудлын шийдлийг заагаагүй, сэдэв, агуулга, үндсэн хэлбэрийн хэв шинжийг тусгаагүй гэхдээ гурвалсан холбоог тодорхой хэмжээгээр харуулсан

хувилбар юм. Хэлбэрийн талаас нь авч үзвэл “Сайн уу, Сайнаа” болон “Нандин” нэвтрүүлгийг “ток шоуны шинж”-тэй гэж үзэж болно.

Ток шоу гэж телевизүүдийн тодотгож байгаа есөн нэвтрүүлэгт хийсэн бичил харьцуулалтаас харахад, энэ төрлийн нэвтрүүлгийн зорилго, онцлогийг бүрэн гаргаж чадаагүй, хэлбэр төдий “ток шоу шинж”- тэй нэвтрүүлгүүд байна. Гэхдээ гаднах хэлбэр буюу “үндсэн гурвалжинг” дуурайснаас бусдаар ток шоуны уламжлалт хэв шинжийг агуулсан өгөгдөл, шийдэл, сэдвийн сонголттой нэвтрүүлэг алга байгаа юм. Хөтлөгчдийн мэргэжлийн ур чадвар, эрэл хайгуул дутмаг, ток шоуны мөн чанарыг ойлголгүй хэт хэлбэр хөөсөн тал ажиглагдлаа.

ОНМХ-ийн системийн нэг хэсэг телевизийн салбар цахим мэдээллийн хэрэгсэлтэй өрсөлдөх хэрэгцээ шаардлагаас улбаалан хэрэгслийн онцлог, давуу талаа илүү харуулсан бүтээл хийх шаардлагатай болж байна. Одоогоор интернетээс хүмүүс сонирхогчийн бичлэг, телевизээр нэгэнт гарсан бүтээлүүдийг үзэж байгаа боловч энэ бол түр зуурын асуудал билээ. Технологийн хурдацтай хөгжил айл бүрийн хойморт байдаг зурагт гэсэн цахилгаан хэрэгслийг компьютер,

холбооны хэрэгсэл, кино театр гээд цогц хэрэглээ нэгэнт болгосон. Цаашдаа конвергенц улам хүчтэй явагдах нь ойлгомжтой байна. Тиймээс дэлхийд хөгжлөөрөө тэргүүлэгч орнууд телевиз үзэлтийг хувь бус бүлгийн шинжтэй, гэр бүлийн бүх гишүүн үздэг уламжлалт хэлбэрийг тодорхой хэмжээгээр хадгалж үлдэхийг зорьж байна. Бүтээлийн агуулга хэлбэрээр дамжуулж энэ зорилгоо биелүүлэхийг хичээж буйн илрэл нь холимог хөтөлбөрүүд юм. Үзэгчид урт сунжирсан уйтгарт яриа, шийдэл нь тодорхойгүй асуудлуудыг сонсохоос илүү сонирхолтой өгөгдөл, хүлээн авагчдын аль аль бүлэгт ч таалагдаж болох янз бүрийн гарцыг нь зааж өгч буй ток шоу сонирхсоор байна. Дэлхийн телевиз үзэлтийн судалгаанд ч энэ төрлийн нэвтрүүлгүүдээс реалити болон варьетте шоу тэргүүлж, ток шоу үзэлтээрээ удаалж байгаа билээ. Эрэлттэй нэвтрүүлгийн жагсаалтыг тэргүүлэгчдийн нэг ток шоу манайд мэргэжлийн түвшинд хийгдэхгүй байгаа нь олон талт хүчин зүйлээс хамаарах нь тодорхой юм. Гэхдээ хүлээн авагчийн эрэлтээс үүдэлтэй нийлүүлт хийх нь зах зээлийн хууль учраас одоогоор хоосон байгаа орон зайд ток шоу шинжтэй бус

«

Ток шоу гэж телевизүүдийн тодотгож байгаа есөн нэвтрүүлэгт хийсэн бичил харьцуулалтаас харахад, энэ төрлийн нэвтрүүлгийн зорилго, онцлогийг бүрэн гаргаж чадаагүй, хэлбэр төдий “ток шоу шинж”-тэй нэвтрүүлгүүд байна. Гэхдээ гаднах хэлбэр буюу “үндсэн гурвалжинг” дуурайснаас бусдаар ток шоуны уламжлалт хэв шинжийг агуулсан өгөгдөл, шийдэл, сэдвийн сонголттой нэвтрүүлэг алга байгаа юм. Хөтлөгчдийн мэргэжлийн ур чадвар, эрэл хайгуул дутмаг, ток шоуны мөн чанарыг ойлголгүй хэт хэлбэр хөөсөн тал ажиглагдлаа

»

харин жинхэнэ ток шоу хийж чадвал салбар доторх төдийгүй хэрэгсэл хоорондын өрсөлдөөнд ялгарч, дотоодын телевизийн салбарын хөгжлийг нэг шат ахиулах том алхам болно.

Ишлэл

- ¹ЦвикВ.Л. Классическая теория жанров и современные телевизионные форматы // Вестник Моск. ун-та. Сер. 10. Журналистика. 2010. № 6. С.52.
- ²www.viur.ru., Продюсерский центр “Виур”. Актерская студия.
- ³М.Зулкафиль. Сэтгүүлчин ур чадвар. УБ. 2009. х.280

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Жадамбаа Ц. “Телевизийн шинэчлэл улсын хөгжилд” илтгэл. Телевизүүдийн чуулган. УБ., 2014
2. Зулькафиль М. Сэтгүүлчийн ур чадвар. УБ., 2009
3. Maxima media. 2014 оны телевиз үзэлтийн нэгдсэн судалгааны тайлан.
4. Нацагдорж Б. Телевизийн нийтлэл, нэвтрүүлгийн хэл найруулга, хэрэглээ соёлын зарим асуудал. УБ., 2012
5. Норовсүрэн Л, Ариунзаяа Н. Телевизийн сэтгүүл зүй. УБ., 2009

6. Цвик В. Л. Классическая теория жанров и современные телевизионные форматы // Вестник Моск. ун-та. Сер. 10. Журналистика. 2010. № 6.

7. Eastman S.T, Ferguson D.A. Media programming: strategies and practices. Cengage learning., 2012
8. Lotz Amanda D. The Television will be Revolutionized. New York., 2007
9. www.viur.ru., Продюсерский центр “Виур”

Резюме

В настоящей статье автор затрагивает проблемы развития ток шоу. На нынешнем этапе ток-шоу относятся к числу самых рейтинговых передач. Оно относительно молодой жанр на отечественном телевидении. И прошел этап становления, но его жанровое определение представляет некоторую проблему в современной телевидение. Анализируя уровень развития телевидения страны и конкретные проблемы, автор предлагает возможные варианты их решения.